



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/128


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 5/07 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай тэмцэх арга хэмжээний “Нэг цэгийн үйлчилгээний” бэлтгэл бэлэн байдлыг хангах, түргэвчилсэн тестийн нөөцийг бүрдүүлэхээр шинжилгээний оношлуур худалдан авах санхүүжилтэд нийт 120,000,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.
2. Тус арга хэмжээнд зарцуулах 120,000,000 төгрөг (нэг зуун хорин сая)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2022 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 14-ний өдрийн
А/128 дугаар захирамжийн хавсралт

СУМДЫН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ
ТҮРГЭВЧИЛСЭН ТЕСТИЙН НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ
САНХҮҮЖИЛТ

№	Хүлээн авах байгууллагын нэр	Нийлүүлэх байгууллагын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1.	Аймгийн Онцгой байдлын газар	“Акютест” ХХК	10000	12,000	120,000,00 0
Нийт дүн			10000		120,000,00 0

-oOo-